

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Азийн эмэгтэйчүүдийн төлөөх залбирал 2

Бид Бурханы өмнө Түүний нүдээр гэм нүглээ хараад, Бурхан биднийг уучилж, аварсанд маш их талархдаг. Мөн бид өдөр бүр ийм байдлаар Бурханд зүрх сэтгэл, оюун бодлоо түүнд өргөх үед Тэрээр Бурхан ажиллаж эхэлдэг бөгөөд Түүний үгийг дуулгавартай дагаснаар Бурханыг дагах хүч чадал, ялгах чадварыг Тэр өгдөг.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Эзэн минь, Вьетнамд бичиг үсэг тайлагдаагүй хүмүүсийн түвшин маш өндөр хэвээр байгаа бөгөөд хөгжиж буй нийгэмд эмэгтэйчүүдэд уншиж, бичиж сурах боломж нэмэгдэхийн төлөө залбирч байна (Нех. 8:8)
2. Бурхан минь, Камбож дахь манай үйлчлэлийн багийнхан бие биенээ хайрлаж, дэмжиж, нийгэмд гэрэл болоход мэргэн ухааныг өгөх болтугай (Иохан 13:35)
3. Индонезийн олон сая эмэгтэйчүүдэд Бурханы үгийг сонсож, эмэгтэйчүүдийн асуудлаар боловсрол эзэмшүүлэх боломжийг Гуамын КТWR-р дамжуулан орон нутгийн 80 станцаас дамжуулан нэвтрүүлэх болосны төлөө Эзэн минь Таныг магтъя. (2 Кор. 9:6-7)
4. Бурхан минь, бид Балбын эмэгтэйчүүд санхүүгийн хувьд бие даасан байхын тулд ажил хийх, бизнес эрхлэх зэрэг эдийн засгийн боломжууд шударгаар нэмэгдэхийн төлөө залбирч байна. (Сур. 31:8-9)
5. Аав аа, Монголын гэр бүлүүд нөхөр нь эхнэрээ хайрлаж, хүндэлж, эхнэр нь нөхөртөө захирагдах болтугай (1 Петр 3:1-7)

6. Эзэн минь, хүүхдүүдийнхээ хэрэгцээг хангахын тулд шаргуу ажиллаж буй Филиппин дэх өрх толгойлсон эхчүүдийг Хангагч, Тайвшруулагч нь Та байгаарай. (Ис. 41:13)
7. Эзэн минь, бид Пакистан дахь эмэгтэйчүүдийн дундтулгардаг ажлын байрны дарамт, тааламжгүй хөдөлмөрийн нөхцөл, бага цалингаас ангид байлгахын төлөө бид залбирч байна. (Сургаалт үгс 22:2)
8. Аав аа, бид Хойд Солонгосын гадаадад суралцаж буй христийн шашинтай оюутнуудыг эх орондоо буцаж ирэхэд нь аюулгүй байхын төлөө, тэдний тогтлолцоо өөрчлөгдөхийн төлөө залбирч байна. (Иош. 1:9)
9. Бурхан минь ээ, Папуа Шинэ Гвинейн засгийн газар хүчирхийлэл, тогтворгүй байдлын эсрэг тэмцэж байгаа хүмүүст мэргэн ухаан өгөөч. (Сур. 2:6)
10. ЭЗЭН, Мьянмарт үргэлжилсэн цэргийн мөргөлдөөн, байнга гарч байна. Байгалийн гамшигт нэрвэгдсэн гэр бүлүүдийг хамгаалж, халамжлаач. (Нахум 1:7)
11. Бурхан минь, Энэтхэгт сургууль завсардалт ихсээд зогсохгүй охидын нас баралтын түвшин хөвгүүдийнхээс өндөр байгаа нөхцөл байдлыг Та өөрчлөөч. (Иаков 1:2-4)
12. Аав аа, Япончуудын дийлэнх нь танд итгэдэггүй, харин шинтогийн бурхдад мөргөдөг хуурамч сүнслэг байдлыг Та өөрчлөөч. (Ис. 45:5-6)
13. Бурхан минь, Малайзын хуулинд өөрчлөлт оруулахын тулд удирдагчдын зүрх сэтгэлийг Та өөрчлөөч. Хүүхдийн гэрлэлт, хүйсийн хүчирхийллийг зогсоож, бүгдэд тэгш эрх бий болтугай. (Флп. 2:13)
14. Эзэн минь, Афганистанд ажил эрхлэх, сургуульд явах, олон нийтийн байгууллагад орохыг хориглосон эмэгтэйчүүдийн эрхийг сэргээхийн төлөө бид залбирч байна (Эх.16:13)
15. Хятадын хүн амын бараг 20% нь 60 ба түүнээс дээш насныхан байна. Аав аа, бид Хятад дахь өндөр настай эмэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн төлөө залбирч байна. (Дуу. 42:11)
16. Бурхан минь, Сингапурт байгаа итгэгчид сүнсээр өсөж, Бурханы хүч чадал, баяр баясгаланг бэрхшээлийг даван туулах боломжийг өгөөч (Иаков 1:2-4)
17. Вьетнам дахь олон эмэгтэйчүүд Найдвар доторх эмэгтэйчүүд хөтөлбөрийг сонссоныхоо дараа Есүсийг мэддэг бөгөөд тэд түүний нүдэнд үнэ цэнэтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөг болсны төлөө ЭЗЭН Таныг магтъя. (Ис. 43:4)



18. Аав аа, Филиппин эхнэр нөхрүүд харилцаагаа бэхжүүлэхийн тулд хайрлцаагаа хэрхэн сайжруулахад суралцах болтугай. Архи уусан нөхрүүдийг чөлөөлж, хүчирхийлэлд өртсөн эхнэрүүдийг хамгаалагч нь Та байх болтугай. (Дуу. 50:5)
19. Эзэн минь, Балбын эмэгтэйчүүдийг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхахаас хамгаалж, тэдний сэтгэл санааны болон оюун санааг эрүүл байлгах шинэ харилцаануудыг тэд олох болтугай (Дуу. 91:4)
20. Христийн итгэлт Монгол ээж, эмээ нар үр хүүхэд, ач зээ нараа Библийн дагуу удирдан чиглүүлж жинхэнэ дагалдагчыг бий болгох болтугай. (2 Тим. 1:3-5)
21. Индонезид хүнсний үнэ огцом өсөж, ядуу гэр бүлүүд хоол хүнс худалдаж авах гэж тэмцэж байгаа тул эдгээр гэр бүлүүдийг өлсгөхгүйн тулд өдөр тутмынх нь хэрэгцээг Та хангаач. (Флп. 4:19)
22. Эзэн минь, үргүйдэл нь Пакистан эмэгтэйчүүдийн дунд хамгийн том асуудал болсон үргүйдлийг Та шийдэж үр хүүхдийг өгөх болтугай. (Дуу. 127:3)
23. Аав аа, Өмнөд Солонгост болзох хүчирхийлэл эрс нэмэгдэж байгаа энэ үед эрчүүд эмэгтэйчүүдийг хүндэлж, уур хилэн, хүчирхийлэл үйлдэх хандлагаа Таны Үгээр өөрчлөх болтугай (2 Кор. 5:7)
24. Эзэн минь, Камбожийн эмэгтэйчүүдийг ажлын байр, ур чадварын сургалт, цалингийн шударга үнэлгээгээр дамжуулан санхүүгийн тогтвортой байдлыг бий болгоход туслаач. (Номлогчийн үгс 7:12)
25. Аав аа, бид Энэтхэгт эмэгтэйчүүд метро, эзгүй зам зэрэг олон нийтийн газар гэмт хэрэгт өртөмтөж байгаа байдлыг Та зогсоогооч. (Ис. 25:4)
26. Бурхан минь, Японы Ното хойгийн газар хөдлөлтөд нэрвэгдэгсдэд туслахын тулд сүм чуулганууд тэдэнд бие махбодийн болон сүнслэг байдлаар үйлчлэхэд нь туслаач. (Дуу. 121:1-2)
27. Эзэн минь, бид таныг Папуа Шинэ Гвиней дахь Wantok Radio Light-тай хамтран ажиллах боломжийг өгсөнд магтя (Мат. 26:41)

28. Бурхан минь, 2023 оны газар хөдлөлтөд гэр бүлийн гишүүд болон эд хөрөнгөө алдсан Афганистаны эмэгтэйчүүдэд амар тайван, эдгэрэлтийг авчир. (Флп. 4:7-9)
29. Хятад нөхрөөсөө бие болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлж, хамгаалаач. Цагдаагийн байгууллага гэр бүлийн хүчирхийллийн хэргийг зөвхөн гэр бүлийн асуудал хэмээн үздэг байдлыг өөрчлөх болтугай. (2 Сам. 22:49)
30. Аав аа, Малайз дахь TWR Women of Hope багийн санхүүгийн боломжгүй хүмүүст ариун цэврийн хэрэглэлийг үнэ төлбөргүй өгөх төлөвлөгөөг Та ерөөгөөч. (Дэд хууль 15:7-8)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. 2024/06/28нд болох Улсын их хурлын сонгуулиар Эзэ нээс эмээдэг, шударга удирдагч нар гарч, Монгол ул сын өнөөгийн амьдрал өөрчлөгдөж сайн сайхан боло хын төлөө залбирч байна.
2. Өсвөр насны хүүхдүүдийн хамгаалалтын төлөө. Уруу т атлага болон буруу зам руу орж амьдралдаа алдаа хий хгүй байхын төлөө. Мансууран, архи ууж буруу зүйлс ийг сонирхож алдахгүй байхын төлөө залбирч байна.
3. өвөл зуднаар малаа алдсан малчдыг Эзэн та хамгаал ж, хангаж амар тайвныг өгөх болтугай. 2024 онд бол ох УИХ-н сонгууль шударга болж,

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.